

# ГЭР БҮЛЭЭРЭЭ СУРАЛЦАХ ЗААВАРЧИЛГАА





Shepherds Global Classroom нь дэлхий даяар өсөн нэмэгдэж буй христитгэлт удирдагчдад зориулсан сургалтын хөтөлбөрөөр дамжуулан Христийн Биенийг сургаж бэлтгэх зорилготой үйлчлэл юм. Бид дэлхийн улс орон бүрийн сүнслэг сургагч багш нарын гар дээр 20 курс хөтөлбөрийг хүргэх замаар тухайн орон нутаг, уугуул иргэдийн сургалтын хөтөлбөрийг олшруулж нэмэгдүүлэхийг зорьж байна.

Энэхүү хичээлийг дараах холбоосоор үнэгүй татаж авах боломжтой: <https://www.shepherdsglobal.org/courses>

Зохиогчийн эрх © 2023 Shepherds Global Classroom

Англи хэл дээрх Эхний хувилбараас монгол хэлнээ орчуулсан Л. Амартүвшин, А. Хүслэн

Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Бүх эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи 2019 хувилбараас ашиглав.

## **Бага насны хүүхдүүдэд зориулсан асуулт ба хариултууд**

Бичсэн: Жонатан Арнольд

From Johnathan Arnold's book, *Holy Joys Kids' Catechism*, 2022. For a print edition of this catechism with beautiful illustrations, visit <https://holyjoys.org/shop>. Used by permission.

## **Хүүхдүүдэд зориулсан асуулт ба хариултууд**

Бичсэн: Др. Матт Фрийдмен, Др. Рэй Ийсли

From Dr. Matt Friedeman's book, *Discipleship in the Home*, (Wilmore: Francis Asbury Society, 2010), pp. 125-143.

Used by permission, slightly abbreviated from 126 to 116 questions, with minor changes.

## **Сургаалт үгс номын зарчмууд**

Бичигч: Др. Стефен К. Гибсон

## **Зөвшөөрөлтэй холбоотой заавар:**

Дараах зааврын дагуу энэхүү номыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэ төлбөргүйгээр хэвлэж, тараах боломжтой. Үүнд: (1). Номын агуулгыг ямар ч байдлаар өөрчилж болохгүй; (2). Олшруулж хэвлэхдээ ашгийн төлөө зарж болохгүй; (3). Боловсролын байгууллагууд сургалтын төлбөр авч болох ч энэхүү номыг үнэгүй ашиглах/олшруулж хэвлэх боломжтой; (4). Shepherds Global Classroom байгууллагын зөвшөөрөл, удирдамжгүйгээр номыг орчуулж болохгүй.

# Гарчиг

Элч нарын итгэлийн тунхаг.....	6
Эзэний заасан залбирал .....	7
Эцэг эхчүүдэд: Зааварчилгаа 1 ба 2 .....	9
Бага насны хүүхдүүдэд зориулсан асуулт ба хариултууд.....	13
Хүүхдүүдэд зориулсан асуулт ба хариултууд ...	21
Эцэг эхчүүдэд: Зааварчилгаа 3.....	43
Сургаалт үгс номын зарчмууд .....	45

# Элч нарын итгэлийн тунхаг

Би газар тэнгэрийг бүтээгч аугаа хүчирхэг  
Бурхан Эцэгт итгэдэг.

Ариун Сүнсээр бүтээгдэж,  
онгон Мариас мэндэлсэн,  
Понти Пилат захирагчийн үед зовж явсан,  
цовдлогдон нас барж оршуулагдаад,  
гурав хоногийн дотор үхлээс дахин амь орсон,  
тэгээд тэнгэрт одож,  
аугаа хүчирхэг Бурхан Эцэгийнхээ  
баруун гарын хүндэт суудалд заларсан,  
дахин ирж үхсэн амьд бүх хүнийг шүүх  
Түүний цорын ганц хүү бидний Их Эзэн  
Есүс Христэд би итгэдэг.

Би Ариун Сүнсэнд итгэдэг.  
Би Ариун нэгдмэл цуглаан,  
ариун хүмүүсийн нөхөрлөл,  
гэмд үзүүлэх уучлал,  
дахин амилалт болон  
мөнхийн амьдралд итгэдэг. Амен.

# Эзэний заасан залбирал

Тэнгэр дэх, бидний Эцэг ээ,  
Таны алдар ариунаар дуurstугай.  
Таны хаанчлал иртүгэй.  
Таны таалал тэнгэрт шигээ  
Газарт бас биелтүгэй.  
Бидний өдөр тутмын хүнсийг  
Өнөөдөр бидэнд хайрлаач.  
Бид өртнүүдээ уучилсны адил  
Бидний өрийг бас уучлаач.  
Биднийг уруу татлагад бүү автуулаач,  
Ёрын муугаас гэтэлгээч.  
Хаанчлал, хүч чадал,  
алдар суу мөнхөд Таных.  
Амен

- Матай 6:9-13



# Эцэг эхчүүдэд:

## Зааварчилгаа 1 ба 2

### Асуулт хариултаар зааж сургах нь

Асуулт асууж, богино бөгөөд энгийн хариулт өгөх нь олон зууны туршид ашиглаж ирсэн үр дүнтэй сургалтын арга юм. Энэ номын асуулт, хариултууд нь христитгэлийн үндсэн итгэл үнэмшлүүдийг танилцуулдаг.

**Зааварчилгаа 1** нь маш бага насны хүүхдүүдэд заахад тустай. Энэ нь тэднийг өсөхөд цаашдын зааварчилгааны бат бэх суурь байх болно.

**Зааварчилгаа 2** нь хүүхдүүд болон итгэлд ирсэн шинэ хүнд заахад тустай. Өгөгдсөн хариултууд нь богино тайлбартай бөгөөд эдгээр нь цаашдын ярилцлага болон суралцах боломжуудыг олгоно. Энэхүү сургалт нь байшингийн торх адил (өөрөөрөө бүрэн гүйцэд биш ч) христитгэлийн нарийн ширийн зүйлийг барьж босгох бүтцийг танилцуулдаг.

### Гэр бүлээрээ эдгээр зааварчилгааг хэрхэн ашиглах талаар

Эдгээр эх сурвалжийн аль нэгийг зөв ашиглахын тулд асуулт бүрийн хариултыг яг бичсэнээр нь цээжлэх ёстой. Хариултуудыг хураангуйлах эсвэл дахин найруулах шаардлагагүй. Харин яг тэр чигээр нь унших хэрэгтэй. Тэр чигээр нь үгсийг цээжлэх нь урт хугацааны санах ойд тусалдаг

бөгөөд суралцагчид нягт нарийвчлалтай байхад тусалдаг.

Энэ номын асуулт, хариултуудыг шалгахад өдөр бүр 10 минутыг зарцуулаарай. Зарим гэр бүл хамтдаа хооллох цагаа суралцахад хамгийн тохиромжтой цаг гэж үздэг.

Зөвхөн заах цагийг удирдаж буй хүн энэ номыг гартаа барих ёстой. Удирдагч асуултыг уншаад хариултыг хэлэхэд бусад нь сонсоно, дараа нь бүгд хамтдаа хэлнэ.

Асуулт, хариултыг уншихыг давтан, бага насны хүүхдийг дагуулан хэлүүлээрэй. Насанд хүрсэн хүн асуултыг үргэлжлүүлэн давтана. Аажмаар (хэдэн өдрийн хугацаанд). хүүхэд үгсийг цээжлээд, тусламжгүйгээр хэлж чаддаг болоход насанд хүрэгч хариултыг хэлэх шаардлагагүй болно. Насанд хүрэгч асууж, хүүхэд хариулна. Энэ бол асуулт-хариултаар суралцахын үндэс юм.

## **Зааварчилгаа 2-д зориулсан нэмэлт заавар**

Өмнөх хариултыг бүгд бараг цээжилсэн тохиолдолд шинэ асуулт бүрийг нэмнэ үү.

Жагсаалтын дагуу уншихдаа, давтсаар, давтсаар, үргэлжлүүлэн давтсаар, сүүлийн асуулт-хариултын ихэнх үгсийг цээжилсэн тохиолдолд аажмаар асуултуудаа нэмээрэй.

Бүх хэсгийн асуултуудыг хамтад нь хэлж чаддаг болох, хариултуудыг богино хугацааны санах ойгоос урт хугацааны санах ойд авчрахын тулд долоо хоногт нэг удаа бүх хэсгийг давтаарай.

**Шинэ зүйлсийг аажмаар нэмж, давталтыг үргэлжлүүлнэ үү** – энэ хоёр арга нь багш, найз нөхөд эсвэл эцэг эхийн удирдлага дор багахан цаг зарцуулсан суралцагчдын хувьд гайхалтай үр дүнтэй байх болно. Суралцах хичээлийг хөгжилтэй болгож, суралцагчийн амжилтыг тэмдэглээрэй.

Та асуулт, хариултуудыг өдөр тутмын гэр бүлийн мөргөлийнхөө нэг хэсэг болгох ч боломжтой. Та тэдгээрийг хүүхдийн цуглааны үйлчлэлд болон хүүхдийн жижиг бүлгүүдийн хооронд тэмцээн уралдаан хийхдээ хамт ашиглаж болно. Та суралцагчдад ойлгоход туслах нэмэлт тайлбар, жишээг боловсруулж болно.

## **Гэр бүлээрээ хамт мөргөлийн цаг хийх төлөвлөгөө**

Гэр бүлээрээ хамтдаа мөргөлийн цаг гаргах олон арга зам бий. Гэр бүлийн мөргөлдөө эдгээр зааварчилгааг ашиглаж болох боломжит дарааллыг танилцуулж байна:

1. Магтуу (чуулганы сүлд дуу). дуулах.
2. **Элч нарын итгэлийн тунхаг** унших.
3. **Асуулт, хариултуудын** хэсгийг давтах, цээжлэх цаг
4. Библийн нэг бүлэг эсвэл хэсгийг унших (Матай, Марк, Лук, Иохан номуудыг эхнээс нь уншиж эхлээрэй).
5. Хамтдаа залбирах. Залбирахаасаа өмнө гэр бүлийн гишүүдээс юуны талаар залбирахыг хүсэж байгааг нь асуугаарай (Та "Бид чиний төлөө хэрхэн залбирах вэ?" эсвэл "Бид бусдын төлөө хэрхэн залбирах вэ?" гэж хэлж болно.)
6. **Эзэний заасан залбирлаар** төгсгөх.

# **Зааварчилгаа 1**

## **Бага насны хүүхдүүдэд зориулсан асуулт ба хариултууд**

### **Эхний асуултууд**

1. Аав, ээжээс ч илүү хэн чамайг хайрладаг билээ?

Хариулт: Бурхан

2. Бурхан чамайг яагаад бүтээсэн бэ?

Хариулт: Жаргалтай байхын тулд

3. Чи хэрхэн жаргалтай байж чадах вэ?

Хариулт: Бурханыг хайрласнаар

4. Өөр ямар нэгэн зүйл чамайг үүрд жаргалтай болгож чадах уу?

Хариулт: Үгүй

### **Бурхан**

5. Хэдэн бурхан байдаг вэ?

Хариулт: Нэг

6. Бурханы дотор хэдэн бодгаль (хүн) байдаг вэ?

Хариулт: Гурав

7. Бурханы дотор байгаа эхний хүн хэн бэ?

Хариулт: Эцэг

8. Бурханы дотор байгаа хоёр дахь хүн хэн бэ?

Хариулт: Хүү

9. Бурханы дотор байгаа гурав дахь хүн хэн бэ?

Хариулт: Ариун Сүнс

### **Бүтээл**

10. Бүх зүйлийг хэн бүтээсэн бэ?

Хариулт: Эцэг Бурхан

11. Бурхан бүх зүйлийг хэнээр дамжуулан бүтээсэн бэ?

Хариулт: Хүү ба Сүнсээр

12. Бурхан бүх зүйлийг хэрхэн бүтээх чадвартай вэ?

Хариулт: Тэр бол аугаа хүчирхэг (Төгс хүчит)

### **Хүн төрөлхтөн**

13. Бурхан чамайг хэрхэн бүтээсэн бэ?

Хариулт: Өөрийнхөө дүр төрхөөр

14. Энэ нь чамайг хэрхэн тайвшруулж байна вэ?

Хариулт: Би Бурханд чухал юм.

15. Хүн бүр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн тул бид тэдэнд хэрхэн хандах ёстой вэ?

Хариулт: Эелдэг, хүндэтгэлтэйгээр.

## **Нүгэл**

16. Анхны эрэгтэй, эмэгтэй хүн хэн байсан бэ?

Хариулт: Адам ба Ева

17. Адам, Ева хоёр юу хийсэн бэ?

Хариулт: Тэд нүгэл үйлдсэн.

18. Нүгэл гэж юу вэ?

Хариулт: Бурханд дуулгаваргүй байх

19. Нүглийн үр дагавар юу вэ?

Хариулт: Үхэл

## **Биежилт (Бурхан хүн болсон)**

20. Биднийг нүгэл болон үхлээс аврахын тулд Бурхан хэнийг илгээсэн бэ?

Хариулт: Өөрийн цорын ганц Хүүгээ

21. Бурханы Хүү хэн бэ?

Хариулт: Есүс Христ

22. Есүсийн ээж хэн байсан бэ?

Хариулт: Онгон Мариа

23. Бяцхан Есүсийг Мариад хэн өгсөн бэ?

Хариулт: Ариун Сүнс

## **Эвлэрүүлэл**

24. Есүс хэрхэн нас барсан бэ?

Хариулт: Тэр загалмайд цовдлогдсон.

25. Есүс яагаад нас барсан бэ?

Хариулт: Бидний нүглийн төлөө

26. Гурав дахь өдөр юу болсон бэ?

Хариулт: Тэр амилсан.

27. Есүс нас барж, амилсан учраас бид юунд итгэдэг вэ?

Хариулт: Тэр бол Эзэн.

## **Аврал**

28. Есүс хаашаа явсан бэ?

Хариулт: Тэнгэр дэх Эцэг рүүгээ

29. Есүс одоо юу хийж байна вэ?

Хариулт: Хаан ёсоор захирч байна.

30. Есүс яагаад дахин ирж байгаа вэ?

Хариулт: Хүн бүрийг шүүхээр

31. Чи аврагдахын тулд юу хийх ёстой вэ?

Хариулт: Есүст итгэх

32. Хэрэв чи нүгэл үйлдвэл юу хийх ёстой вэ?

Хариулт: Бурханаас уучлалт гуйх.

## **Ариун Сүнс ба Чуулган**

33. Бурхан биднийг аврахын тулд өөр хэнийг илгээсэн бэ?

Хариулт: Ариун Сүнсийг

34. Ариун Сүнс чиний төлөө юу хийдэг вэ?

Хариулт: Тэр надад тусалдаг.

35. Ариун Сүнс чамд хэрхэн тусалдаг вэ?

Хариулт: Чуулганаар дамжуулан

36. Чуулган гэж юу вэ?

Хариулт: Бурханы гэр бүл

37. Чи хэрхэн чуулганд нэгдэх вэ?

Хариулт: Баптисмаар дамжуулан

## **Тайтгарал**

38. Чи айх хэрэгтэй юу?

Хариулт: Үгүй

39. Чи яагаад айх хэрэггүй вэ?

Хариулт: Бурхан надтай хамт байгаа.

40. Чи Бурханыг харж чадах уу?

Хариулт: Үгүй

41. Бурхан чамайг харж чадах уу?

Хариулт: Тийм

## **Ариусгал**

42. Бурхан чамайг хэнтэй адилхан байлгахыг хүсдэг вэ?

Хариулт: Есүстэй

43. Эхний дөрвөн тушаалд чиний төлөөх Бурханы хүсэл юу вэ?

Хариулт: Бурханыг хайрлах

44. Сүүлийн зургаан тушаалд чиний төлөөх Бурханы хүсэл юу вэ?

Хариулт: Хөршөө хайрлах

45. Бурхан чамайг хэнд дуулгавартай байлгахыг хүсдэг вэ?

Хариулт: Ээж, аавдаа

46. Залбирал гэж юу вэ?

Хариулт: Бурхантай ярих

47. Есүс бидэнд юу залбирахыг заасан бэ?

Хариулт: Эзэний заасан залбирлыг

48. Бурхан чамтай хэрхэн ярьдаг вэ?

Хариулт: Библиэр дамжуулан

49. Библи гэж юу вэ?

Хариулт: Бурханы Үг

### **Эцсийн цаг үе**

50. Бурхан юуг шинээр бүтээж байна вэ?

Хариулт: Бүх зүйлийг

51. Бурхан үхэгсдээс юуг амилуулах вэ?

Хариулт: Бидний биеийг

52. Бид одоо юуг эдэлдэг вэ, мөн үүрд мөнхөд эдлэхийг тэсэн ядан хүлээж байна вэ?

Хариулт: Мөнхийн амь

### **Арван тушаал (хялбаршуулсан)**

Би бол чамайг аварсан чиний Бурхан Эзэн.

1. Чи Надаас өөр бурхадтай байж болохгүй.
2. Чи шүтээн хийж болохгүй.
3. Чи Эзэн Бурханыхаа нэрийг дэмий ашиглаж болохгүй.
4. Амралтын өдрийг ариун байлгахаар санаарай.
5. Эцэг эхээ хүндэл.
6. Чи хүн алж болохгүй.
7. Чи завхайрч болохгүй.
8. Чи хулгай хийж болохгүй.
9. Чи худал хэлж болохгүй.
10. Чи шунахайрч болохгүй.



# **Зааварчилгаа 2**

## **Хүүхдүүдэд зориулсан асуулт ба хариултууд**

### **Библийн талаарх асуултууд**

1. Бурханыг хэрхэн хайрлаж, дуулгавартай байхыг бид хаанаас сурдаг вэ?

Хариулт: Библиэс

2. Библи гэж юу вэ?

Хариулт: Бурханы амьсгалаар бичигдсэн 66 ном бөгөөд бидэнд Бурханы талаар болон Түүний адил ариун байхыг заадаг.

3. Библийг хэн бичсэн бэ?

Хариулт: 1600 гаруй жилийн хугацаанд Бурханы амьсгал ба заавраар удирдуулсан 40 гаруй хүмүүс.

4. Хууль гэж нэрлэгддэг Библийн таван номыг нэрлэнэ үү.

Хариулт: Эхлэл, Гэтлэл, Леви, Тооллого, Дэд хууль

5. Хуулийн мэдээ сургаал нь юу вэ?

Хариулт: Бурхан ариун бөгөөд биднийг өөртэйгөө адилхан байлгахыг хүсдэг.

6. Хуучин гэрээний түүхийн номуудыг нэрлэнэ үү.

Хариулт: Иошуа, Шүүгчид, Рут, 1 ба 2  
Самуел, 1 ба 2 Хаад, 1 ба 2 Шастир, Езра,  
Нехемиа, Естер

7. Түүхийн номуудын мэдээ сургаал нь юу вэ?

Хариулт: Бид Бурханыг бүх зүрхээрээ  
дагавал сайн зүйлс ирдэг. Үл дагавал муу  
зүйлс ирдэг.

8. Хуучин гэрээний яруу найргийн номуудыг нэрлэнэ үү.

Хариулт: Иов, Дуулал, Сургаалт үгс,  
Номлогчийн үгс, Соломоны дуун

9. Яруу найргийн номуудын мэдээ сургаал нь юу вэ?

Хариулт: Бид бүх нөхцөл байдалд Бурханыг  
хайвал ерөөгдөнө.

10. Хуучин гэрээний их эш үзүүлэгчдийн номуудыг нэрлэнэ үү.

Хариулт: Исаиа, Иеремиа, Гашуудал,  
Езекиел, Даниел

11. Хуучин гэрээний бага эш үзүүлэгчдийн номуудыг нэрлэнэ үү.

Хариулт: Хосеа, Иоел, Амос, Обадиа, Иона,  
Мика, Нахум, Хабаккук, Зефаниа, Хаггаи,  
Зехариа, Малахи

12. Яагаад эдгээрийг "бага" эш үзүүлэгчид гэж нэрлэдэг вэ?

Хариулт: Тэд их эш үзүүлэгчдийн номуудаас богино.

13. Эш үзүүлэгчдийн мэдээ сургаал нь юу вэ?

Хариулт: Бурханы хайр болон хууль руу буцаж ирэх.

14. Шинэ гэрээний Сайнмэдээний номуудыг нэрлэнэ үү.

Хариулт: Матай, Марк, Лук, Иохан

15. Сайнмэдээний номуудын мэдээ сургаал нь юу вэ?

Хариулт: Есүс бидний төлөө ирж, амьдарч, нас барж, амилсан.

16. Есүсийн амиллын дараах анхны чуулганы түүхийг өгүүлсэн номыг нэрлэнэ үү.

Хариулт: Үйлс

17. Үйлс номын мэдээ сургаал нь юу вэ?

Хариулт: Ариун Сүнс чуулганд ирж, Бурханы Үг түгэн тархсан.

18. Паулын захидлуудыг нэрлэнэ үү.

Хариулт: Ром, 1 ба 2 Коринт, Галат, Ефес, Филиппой, Колоссай, 1 ба 2 Тесалоник, 1 ба 2 Тимот, Тит, Филемон

19. Паулын захидлуудын мэдээ сургаал нь юу вэ?

Хариулт: Бурханы нигүүлсэл болон зөвт байдалд амьдрах.

20. Ерөнхий захидлуудыг нэрлэнэ үү.

Хариулт: Еврей, Иаков, 1 ба 2 Петр, 1, 2, 3 Иохан, Иуда

21. Ерөнхий захидлуудын мэдээ сургаал нь юу вэ?

Хариулт: Бурханы хүмүүс энэ дэлхий дээр хэрхэн амьдрах талаар.

22. Библийн сүүлчийн номыг нэрлэнэ үү.

Хариулт: Илчлэл

23. Илчлэл номын мэдээ сургаал нь юу вэ?

Хариулт: Есүс бол хаадын Хаан бөгөөд ялалт байгуулсан чуулганыхаа төлөө удахгүй ирнэ.

24. Библийн 66 номыг бүгдийг нэрлэнэ үү.

Хариулт:

### **Хуучин гэрээ**

Эхлэл, Гэтлэл, Леви, Тооллого, Дэд хууль, Иошуа, Шүүгчид, Рут, 1 ба 2 Самуел, 1 ба 2 Хаад, 1 ба 2 Шастир, Езра, Нехемиа, Естер, Иов, Дуулал, Сургаалт үгс, Номлогчийн үгс, Соломоны дуун, Исаиа, Иеремиа, Гашуудал, Езекиел, Даниел, Хосеа, Иоел, Амос, Обадиа, Иона, Мика,

Нахум, Хабаккук, Зефаниа, Хаггаи,  
Зехариа, Малахи

### **Шинэ гэрээ**

Матай, Марк, Лук, Иохан, Үйлс, Ром, 1 ба 2  
Коринт, Галат, Ефес, Филиппой, Колоссай,  
1 ба 2 Тесалоник, 1 ба 2 Тимот, Тит,  
Филемон, Еврей, Иаков, 1 ба 2 Петр, 1, 2,  
3 Иохан, Иуда, Илчлэл

25. Бурханы амьсгалаар бичигдсэн эдгээр 66  
номын мэдээ сургаал нь юу вэ?

Хариулт: Эдгээр нь Бурханы талаар; бид  
хэрхэн аврагдаж, Есүс Христийн дүр төрх  
рүү өөрчлөгдөх<sup>1</sup>; бид хэрхэн Түүний адил  
ариун байх талаар заадаг.

### **Арван тушаалын талаарх асуултууд**

26. Бурханы тушаал гэж юу вэ?

Хариулт: Бурхан хэн болохыг харуулсан  
зураглал, мөн бид хэн болж чадах тухай  
амлалт.

27. Арван тушаал Библийн аль хэсэгт байдаг вэ?

Хариулт: Гэтлэл 20:1-17-д

---

<sup>1</sup> “бид хэрхэн аврагдаж, Есүс Христийн дүр төрх рүү өөрчлөгдөх”  
гэсэн энэ өгүүлбэрийг анхны хариулт дээр нэмсэн болно.

28. Арван тушаал гэж юу вэ?

Хариулт: Синай уулан дээр Бурханы ард түмэнд өгөгдсөн тушаалууд.

29. Арван тушаалыг хэн өгсөн бэ?

Хариулт: Бурхан

30. Арван тушаалыг хэн хүлээн авсан бэ?

Хариулт: Мосе

31. Эхний тушаал нь “Чи Надаас өөр бурхадтай байж болохгүй” (Гэтлэл 20:3). Энэ тушаал юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бид Бурханыг үргэлж нэгдүгээрт тавих ёстой.

32. Хоёр дахь тушаал нь “Өөртөө зориулан шүтээн... бүү хий” (Гэтлэл 20:4). Энэ тушаал юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бурханаас өөр ямар ч зүйлд мөргөх нь буруу.

33. Гурав дахь тушаал нь “Чи Эзэн Бурханыхаа нэрийг хуурмаг хоосонд бүү дурд” (Гэтлэл 20:7). Энэ тушаал юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бид Бурханы нэрийг дурдахдаа маш их хүндэтгэлтэй хандах ёстой.

34. Дөрөв дэх тушаал нь “Амралтын өдрийг санаж үүнийг ариунаар сахь” (Гэтлэл 20:8). Энэ тушаал юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Ням гарагт бид Бурханыг хүндэлж, амрах ёстой.

35. Тав дахь тушаал нь “Эцэг эхээ хүндэл” (Гэтлэл 20:12). Энэ тушаал юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бид эцэг эхээ хайрлаж, дуулгавартай байх ёстой.

36. Зургаа дахь тушаал “Чи хүн бүү ал” (Гэтлэл 20:13). Энэ тушаал юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бид бусад хүмүүсийг хууль бусаар алах ёсгүй.

37. Долоо дахь тушаал “Чи бүү завхайр” (Гэтлэл 20:14). Энэ тушаал юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бэлгийн харилцаа нь зөвхөн гэрлэлтэд зориулагдсан.

38. Найм дахь тушаал нь “Чи бүү хулгайл” (Гэтлэл 20:15). Энэ тушаал юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бидэнд хамаарахгүй зүйлсийг авах ёсгүй.

39. Ес дэх тушаал нь “Чи хөршийнхөө эсрэг худал хуурмаг гэрчлэл бүү хий” (Гэтлэл 20:16). Энэ тушаал юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бид үргэлж үнэнийг хэлэх ёстой.

40. Арав дахь тушаал "...Бүү шуна" (Гэтлэл 20:17). Энэ тушаал юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бурханы бидэнд өгсөн зүйлсэд бид сэтгэл хангалуун байх ёстой.

41. Есүс аль хоёр тушаалыг хамгийн агуу тушаал гэж хэлсэн бэ?

Хариулт: "Чи Эзэн Бурханаа бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүч чадлаараа хайрла" гэсэн нь юм. "Чи хөршөө өөрийн адил хайрла" гэсэн нь хоёр дахь нь юм. Эдгээрээс илүү агуу өөр тушаал байхгүй" (Марк 12:30-31).

42. Эдгээр бүх тушаал бидэнд яагаад чухал вэ?

Хариулт: Ариун Бурхан биднээс хүсдэг амьдралыг эдгээр нь тодорхойлдог.

Нэмэлт асуулт: Гэтлэл 20:1-17-д өгөгдсөн Арван тушаалын бүрэн текстийг эш татна уу.

### **Эзэний заасан залбирлын талаарх асуултууд**

43. Эзэний заасан залбирлыг анх хэн залбирсан бэ?

Хариулт: Есүс, тэрээр арван хоёр дагалдагч нарт хэрхэн залбирахыг заахдаа.

44. Эзэний заасан залбирал Библийн аль хэсэгт байдаг вэ?

Хариулт: Матай 6:9-13-д

45. Эзэний заасан залбирлын үгс юу вэ?

Хариулт:

Тэнгэр дэх, бидний Эцэг ээ,  
Таны алдар ариунаар дуурстугай.  
Таны хаанчлал иртүгэй.  
Таны таалал тэнгэрт шигээ  
Газарт бас биелтүгэй.  
Бидний өдөр тутмын хүнсийг  
Өнөөдөр бидэнд хайрлаач.  
Бид өртнүүдээ уучилсны адил  
Бидний өрийг бас уучлаач.  
Биднийг уруу татлагад бүү автуулаач,  
Ёрын муугаас гэтэлгээч.  
Хаанчлал, хүч чадал,  
алдар суу мөнхөд Таных.  
Амен.

46. "Таны алдар ариунаар дуурстугай." гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бид ариун Бурханыг хайрлаж, өргөмжлөхийг хүсдэг.

47. "Таны хаанчлал иртүгэй." гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бурхан бол бидний Хаан. Дэлхийн бүх хүн Түүнийг Хаан гэж мэдэхийг бид хүсдэг.

48. "Таны таалал тэнгэрт шигээ газарт бас биелтүгэй." гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бурханы хүсдэг бүх зүйлийг бид хүсдэг.

49. "Бидний өдөр тутмын хүнсийг өнөөдөр бидэнд хайрлаач." гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бид Бурханаас бүх хэрэгцээг маань хангаж өгөхийг гуйдаг.

50. "Бид өртнүүдээ уучилсны адил бидний өрийг бас уучлаач." гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бид бусдыг уучилдаг шиг биднийг уучлахыг Бурханаас гуйдаг.

51. "Биднийг уруу татлагад бүү автуулаач, ёрын муугаас гэтэлгээч." гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Биднийг бүх нүглээс хамгаалж өгөхийг бид Бурханаас гуйдаг.

52. "Хаанчлал, хүч чадал, алдар суу мөнхөд Таных." гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бурхан бол тэнгэр, газрыг мөнхөд захирдаг, бүхнийг чаддаг Хаан.

53. Эзэний заасан залбирал яагаад чухал вэ?

Хариулт: Бурханыг ариун Эцэг болохын хувьд Түүнд анхаарлаа хандуулахад энэ нь тусалдаг.

## **“Ерөөлтэй еэ” сургаалын асуултууд**

54. “Ерөөлтэй еэ” сургаалын асуултууд гэж юу вэ?

Хариулт: Ариун зан чанарын тухай Есүсийн сургаал.

55. “Ерөөлтэй еэ” сургаал нь Библийн аль хэсэгт байдаг вэ?

Хариулт: Матай 5:3-10

56. “Ерөөлтэй еэ” сургаалыг нэрлэнэ үү.

Хариулт:

Сүнсэндээ ядуус ерөөлтэй еэ!

Тэнгэрийн хаанчлал тэднийх юм.

Гашуудагсад ерөөлтэй еэ!

Тэд тайвшрал авах болно.

Дөлгөөн хүмүүс ерөөлтэй еэ!

Тэд газрыг өвлөх болно.

Зөвт байдлын төлөө өлсөж, цангагч хүмүүс ерөөлтэй еэ!

Тэд хангалуун болох болно.

Энэрэнгүй хүмүүс ерөөлтэй еэ!

Тэд өршөөл энэрлийг хүртэх болно.

Зүрхэндээ цэвэр ариун байгсад ерөөлтэй еэ!

Тэд Бурханыг харах болно.

Амар тайвныг тогтоогч хүмүүс ерөөлтэй еэ!

Тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно.

Зөвт байдлын төлөө хавчигдагсад ерөөлтэй  
еэ!

Тэнгэрийн хаанчлал тэднийх юм.

57. Сүнсэндээ ядуу байх гэдэг нь юу гэсэн  
утгатай вэ?

Хариулт: Нүгэл үйлдсэнээ хүлээн зөвшөөрч,  
Бурханы тусламж хэрэгтэй байх.

58. Гашуудах гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бурханыг гуниглуулдаг зүйлсэд  
гуниглах.

59. Дөлгөөн байх гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Амьдралаа Бурханд захируулахаар  
өгөх.

60. Зөвт байдлын төлөө өлсөж, цангах гэдэг нь  
юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Амьдралдаа Бурханы хэм хэмжээг  
чин сэтгэлээсээ хүсэмжлэх.

61. Энэрэнгүй байх гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бүх хүмүүст өрөвч сэтгэлээр  
хандах.

62. Зүрхэндээ цэвэр ариун байх гэдэг нь юу  
гэсэн утгатай вэ?

Хариулт: Бурханыг бүх зүрхээрээ хайрлах.

63. Амар тайвныг тогтоогч байх гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Хүмүүсийг Бурхантай болон бие биетэйгээ найз байхад туслах.

64. Зөвт байдлын төлөө хавчигдах гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бурханы хаанчлалын төлөө баяртайгаар зовлон амсах.

### **Бурханы талаарх асуултууд**

65. Хэдэн бурхан байдаг вэ?

Хариулт: Зөвхөн нэг Бурхан байдаг.

66. Нэг Бурханы дотор хэдэн бодгаль (хүн) байдаг вэ?

Хариулт: Гурав – Эцэг Бурхан, Хүү Бурхан, Ариун Сүнс Бурхан.

67. Бурханыг хамгийн сайн тодорхойлж болох үг юу вэ?

Хариулт: Бурхан бол ариун.

68. Бурхан хэдэн настай вэ?

Хариулт: Бурхан мөнхийн юм. Тэр үргэлж байсан. Тэр үргэлж байх болно.

69. Бурхан хаана байдаг вэ?

Хариулт: Бурхан өөрийнхөө хүссэн газар бүхэнд байдаг.

70. Бурхан юу хийж чадах вэ?

Хариулт: Бурхан өөрийнхөө хүссэн бүхнийг хийж чадна.

71. Бурхан юу мэддэг вэ?

Хариулт: Бурхан өөрийнхөө мэдэхийг хүссэн бүхнийг мэддэг.

72. Бурханаас илүү хүчтэй зүйл бий юу?

Хариулт: Үгүй

73. Бурхан бол Бүтээгч. Тэр юу бүтээсэн бэ?

Хариулт: Бүхнийг

74. Бурхан чамайг яагаад бүтээсэн бэ?

Хариулт: Ингэснээр Тэр намайг хайрлаж, надаар баясаж чадах юм.

### **Хүн төрөлхтөн, Нүгэл, Авралын талаарх асуултууд**

75. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэж хэн бэ?

Хариулт: Бурханыг мэдэж, хайрлаж чадах хүмүүс.

76. Бидний анхны эцэг эх хэн байсан бэ?

Хариулт: Адам ба Ева

77. Адам, Ева хоёр бусад амьтдаас юугаараа ялгаатай байсан бэ?

Хариулт: Адам, Ева хоёр сүнстэй байсан; амьтад сүнсгүй.

78. Чамд сүнс бий юу?

Хариулт: Тийм ээ, надад хэзээ ч үхэхгүй сүнс бий.

79. Нүгэл гэж юу вэ?

Хариулт: Энэ нь (үндсэндээ) бидэнд мэдүүлсэн Бурханы хуульд дуулгаваргүй байх явдал юм.

80. Нүглээс болж юу болдог вэ?

Хариулт: Энэ нь Бурхантай харилцах хайрын харилцааг маань хохироодог.

81. Анхны нүглийг хэн үйлдсэн бэ?

Хариулт: Адам ба Ева

82. Адам, Ева хоёр ямар буруу зүйл хийсэн бэ?

Хариулт: Тэд Бурханы идэж болохгүй гэсэн жимсийг идсэн бөгөөд Түүнтэй харилцах харилцаагаа тасалсан.

83. Адам, Ева хоёрыг нүгэл үйлдэхэд хэн уруу татсан бэ?

Хариулт: Чөтгөр

84. Бидэнд тэр нүгэл хэрхэн нөлөөлсөн бэ?

Хариулт: Адам, Ева хоёр нүглийг бүх хүн төрөлхтөнд дамжуулсан; бид бүгд төрөхдөө нүгэлтэй төрдөг болсон.

85. Нүгэлтнүүд юуг хүртэх ёстой вэ?

Хариулт: Бурханы шийтгэл болон үхэл.

86. Бид (санаатай) нүгэлтнүүд байвал тэнгэрийн улсад очиж чадах уу?

Хариулт: Үгүй

87. Хэрэв бид нас барахдаа тэнгэрийн улсад очихгүй бол, хаашаа очих вэ?

Хариулт: Тамд.

88. Аврал гэж юу вэ?

Хариулт: Нүглүүдээсээ уучлагдах (Есүсийн бидний төлөөх үхэл, оршуулга, амилалд итгэх итгэлээр) болон Бурханыг хайрлах.

89. Бидэнд аврал яагаад хэрэгтэй вэ?

Хариулт: Бид бүгд нүгэлтнүүд.

90. Авралыг хүлээн авахад юу шаардлагатай вэ?

Хариулт: Бид Христ Есүст итгэх итгэлээр нигүүлслээр аврагддаг.

91. Аврагдах өөр зам бий юу?

Хариулт: Үгүй, бид зөвхөн Христ Есүст итгэх итгэлээр нигүүлслээр аврагдаж чадна.

92. Бид нүглээсээ аврагдахад юу болдог вэ?

Хариулт: Бид Бурханыг болон хөршөө хайрлаж, Түүнийг баярлуулах хүсэл тэмүүлэл маань өсөн нэмэгддэг.

## **Есүсийн талаарх асуултууд**

93. Есүс гэж хэн бэ?

Хариулт: Есүс бол хүн болсон Бурхан, бидний Аврагч.

94. Аврагч гэж хэн бэ?

Хариулт: Биднийг нүглээс аврах цорын ганц Нэгэн.

95. Есүс хүн үү, эсвэл Бурхан уу?

Хариулт: Тэр бол төгс хүн, мөн төгс Бурхан.

96. Есүсийг төрүүлэхэд юу онцгой байсан бэ?

Хариулт: Тэр онгон Мариагаас Ариун Сүнсээр төрсөн.

97. Есүс 2000 жилийн өмнө амьдрахдаа юу хийсэн бэ?

Хариулт: Тэр дагалдагч нартаа зааж, ядууст санаа тавьж, бидний нүглийн төлөө загалмай дээр нас барсан.

98. Нүглийг маань цагаатгана гэдэг нь юу гэсэн үг вэ?

Хариулт: Энэ нь Есүс загалмай дээр нас барахдаа бидний хүртэх ёстой шийтгэлийг өөр дээрээ авсан бөгөөд ингэснээр бид Бурхантай харилцах боломжтой болсон гэсэн үг юм.

99. Есүс нас барсны дараа юу болсон бэ?

Хариулт: Булшинд хэвтүүлсний дараа Тэр амилж, үхлийг ялсан.

### **Ариун Сүнсний талаарх асуултууд**

100. Ариун Сүнс гэж хэн бэ?

Хариулт: Тэр бол Бурхан Гурвалын гурав дахь бодгаль (хүн).

101. Есүсийн амласан ёсоор Ариун Сүнс хэзээ ирсэн бэ?

Хариулт: Есүсийн амиллаас хойш 50 хоногийн дараа, Иудейн Пентэкоост баяраар.

102. Пентэкоост гэж юу вэ?

Хариулт: Чуулганы төрсөн өдөр, Ариун Сүнс Есүст итгэгчдийг дүүргэсэн үе.

103. Ариун Сүнс өнөөдөр юу хийдэг вэ?

Хариулт: Тэр итгэгчдийг ариусгадаг.

104. Ариун Сүнс хүмүүсийг хэрхэн ариусгадаг вэ?

Хариулт: Тэр хүмүүсийн нүглийг зэмлэж, цэвэрлэж, зааж, удирдан чиглүүлж, бидэнд сүнслэг хүч чадал, сүнслэг бэлгүүд болон Сүнсний үр жимсийг өгдөг.

105. Сүнсний үр жимс гэж юу вэ?

Хариулт: Сүнсний үр жимс бол хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл,

сайхан сэтгэл, итгэмжит чанар, дөлгөөн зан, өөрийгөө захирах юм (Галат 5:22-23).

106. Сүнсний бэлэг гэж юу вэ?

Хариулт: Ариун Сүнснээс бидэнд өгөгдсөн, Агуу захирамжийг биелүүлэхэд туслах чадвар юм.

107. Агуу захирамж гэж юу вэ?

Хариулт: Энэ нь Есүс дагалдагч нартаа явж, бүх үндэстнийг дагалдуулах, тэдэнд баптисм хүртээх, Түүний сургаалыг сахин биелүүл хэмээн өгсөн заавар юм.

108. Сүнсний гэрчлэл гэж юу вэ?

Хариулт: Бидний итгэл Бурханыг баярлуулж байгааг таних дотоод мэдлэг.

109. Ариун Сүнс надад хэрхэн тусалж чадах вэ?

Хариулт: Тэр Бурханыг болон Түүний хүслийг бүх зүрхээрээ хайрлахад надад тусалж чадна.

110. "Төгс" Христэд итгэгч байх гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Хариулт: Бурханыг бүх зүрхээрээ, бүх сэтгэлээрээ, бүх хүчээрээ хайрлах.

### **Эцсийн цаг үеийн талаарх асуултууд**

111. Есүс нэгэн өдөр биеэр, харагдахуйц байдлаар эргэн ирэх үү?

Хариулт: Тийм.

112. Есүс яагаад дахин ирэх вэ?

Хариулт: Өөрийн чуулганыг өөртөө авахаар.

113. Энэ нь хэзээ болох вэ?

Хариулт: Бид хэзээ гэдгийг мэдэхгүй, тиймээс үргэлж бэлэн байх ёстой.

114. Бид хэрхэн бэлэн байх вэ?

Хариулт: Бурхантай харилцах хайрын харилцаанд хором бүр амьдрах.

115. Есүс дахин ирсний дараа юу болох вэ?

Хариулт: Бүх хүмүүс шүүгдэж, эцэст нь Сатан ялагдах болно.

116. Сатан ялагдсаны дараа юу болох вэ?

Хариулт: Бид Бурханыг хайрлаж, мөнхөд Түүнд баярлан баясах болно.

## Цээжлэх эшлэлүүд

- Гэтлэл 19:3-6
- Гэтлэл 20:1-17 - Арван тушаал
- Дэд хууль 6:4-9
- Дуулал 1
- Дуулал 23
- Дуулал 24
- Дуулал 121
- Дуулал 139
- Матай 7:21-27
- Матай 28:18-20
- Иохан 3:16-21
- 1 Коринт 13:1-13
- Галат 5:16-25
- Ефес 6:10-17
- Филиппой 2:5-11
- Еврей 12:1-3
- 1 Петр 2:9-12
- Илчлэл 21:4-8



# Эцэг эхчүүдэд: Зааварчилгаа 3

## Энэхүү зааварчилгааны зорилго

Энэхүү зааварчилгаа нь Сургаалт үгс номоос гэр бүл, сургууль эсвэл бусад сургалтын орчинд ашиглах амьдралын зарчмуудыг танилцуулдаг. Энэ материалыг нэг дор, нэг хичээлээр заахаар боловруулаагүй. Өдөр бүр нэг эсвэл хоёр зарчмыг зааж, ярилцах нь хамгийн сайн арга юм.

## Заах арга

- (1) Зарчимтай холбоотой эшлэлүүдийг хэн нэгэн уншина. Хэрэв хэд хэдэн эшлэл байвал эцэг/багш нь аль эшлэлийг ашиглахаа сонгож болно.
- (2) Эцэг/багш нь сонсогчид эшлэлийн үг, өгүүлбэрийг ойлгож байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.
- (3) Дараа нь эцэг/багш эшлэлд үндэслэсэн зарчмыг хуваалцаж болно.
- (4) Эцэг/багш болон бусад хүмүүс тухайн зарчмыг хэрэгжүүлэх амьдралын нөхцөл байдлуудыг тодорхойлж болно.

## **Сургаалт үгс номын ойлголтууд**

*Бурханаас эмээх* нь Сургаалт үгс номын нэг чухал ойлголт юм. Бурханаас зөв зүйтэй эмээх гэдэг нь Тэр хэн болохыг, бид Түүнд дуулгавартай байх ёстойг, мөн дуулгаваргүй байдал нь шүүгдэх болно гэсэн гурван зүйлийг мэдсэн байхыг хэлдэг.

*Мэргэн ухаан* нь Сургаалт үгс номын гол сэдэв юм. Мэргэн ухаантай байх гэдэг нь Бурханы үзэл баримтлал, үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрч, дагана гэсэн үг юм. Бурхан бүх зүйлийг яг байгаагаар нь хардаг, тиймээс Бурханы хэлсэнд итгэж, Түүний зааврыг дагавал бид мэргэн ухаантай байх болно.

Эцэг эх, багш нар Сургаалт үгс номын зарчмуудыг хувьчлан дагаж мөрдөх ёстой. Тэд өөрсдийн амьдралдаа зарчмуудыг хэрэгжүүлж байгаагаа харуулах хэрэгтэй юм. Тэд хүүхдүүд болон суралцагчдадаа зарчмуудыг зааж, амьдралын нөхцөл байдалд тэдгээрийг хэрэглэх арга замыг хайх учиртай.

# **Зааварчилгаа 3**

## **Сургаалт үгс номын зарчмууд**

1. Бурханы мэргэн ухааныг сурах нь миний хийж чадах хамгийн чухал зүйл юм (Сургаалт үгс 2:4-5, Сургаалт үгс 4:5).
2. Би сонссон бүхэндээ итгэх ёсгүй (Сургаалт үгс 14:15).
3. Би шийдвэр гаргах бүрдээ Бурханы хүслийг дагах ёстой, ингэснээр Тэр намайг удирдан чиглүүлж чадна (Сургаалт үгс 3:5-6).
4. Би эцэг, эхийнхээ зөвлөгөө, мэргэн ухааныг сонсох ёстой (Сургаалт үгс 1:8).
5. Сайн зөвлөгөө нь миний амьдралыг ерөөж, бусдад туслах боломжийг надад олгодог (Сургаалт үгс 10:17).
6. Хэрэв би сайн сургаалыг үл тоомсорловол, гамшиг сүйрлийг туулах болно (Сургаалт үгс 13:18).
7. Сайн заавар нь намайг хөгжүүлж, сайжрахад тусалдаг (Сургаалт үгс 9:9).
8. Бурхан намайг хүчирхийлэл үйлдэхгүй, хуурч мэхлэхгүй байхыг хүсдэг (Сургаалт үгс 3:31-32).

9. Би зүрхэндээ зөв сэдэлтэй байх хэрэгтэй (Сургаалт үгс 4:23, Сургаалт үгс 12:5).
10. Бурхан миний хийсэн зүйлийн жинхэнэ шалтгааныг мэддэг (Сургаалт үгс 16:2).
11. Хэрэв би мэдлэг, засах залруулгыг үл тоомсорловол, мунхаг байх болно (Сургаалт үгс 1:22, Сургаалт үгс 12:1).
12. Бурханы хүслийг дагах нь намайг олон гамшиг сүйрлээс хамгаалдаг (Сургаалт үгс 1:33).
13. Би Бурханд итгэж найдсанаар айдасгүй байж чадна (Сургаалт үгс 3:25-26).
14. Би өөрийн ойлголт, чадварт найдахын оронд Бурханд итгэж найдах ёстой (Сургаалт үгс 3:7, Сургаалт үгс 11:2, Сургаалт үгс 12:15).
15. Би нүглээ үүрд нууж чадахгүй (Сургаалт үгс 10:9).
16. Бурханы дүрэм нь намайг хамгаалж, тусалдаг (Сургаалт үгс 6:23-24).
17. Хэрэв би дур хүсэл, сэтгэл хөдлөлөө хянаж чадвал хүчтэй байх болно (Сургаалт үгс 16:32, Сургаалт үгс 25:28).
18. Хэрэв би хайхрамжгүй яривал өөртөө болон бусдад хохирол учруулна (Сургаалт үгс 10:8, Сургаалт үгс 10:21).

19. Намайг буруу зүйл хийхэд нөлөөлдөг хүмүүсээс би хол байх ёстой (Сургаалт үгс 1:10-15, Сургаалт үгс 4:14-15, Сургаалт үгс 14:7, 16).
20. Би өөртөө байлгахыг хүсдэг хүсдэг тийм зан чанартай найз нөхдийг сонгох ёстой (Сургаалт үгс 13:20).
21. Бурхан миний хийдэг бүхнийг хардаг (Сургаалт үгс 5:21, Сургаалт үгс 15:3).
22. Хэрэв би итгэмжит бөгөөд итгэл хүлээсэн байвал найзууд маань намайг үнэлэх болно (Сургаалт үгс 19:22).
23. Хайртай хүмүүстэйгээ амьдралаа хуваалцах нь тансаг амьдралаас дээр (Сургаалт үгс 15:17).
24. Би шийдвэр гаргахаасаа өмнө сайтар бодоход хангалттай цагийг гаргах ёстой (Сургаалт үгс 21:5, Сургаалт үгс 19:2).
25. Хэрэв би мэргэн ухаантай бол мэдлэгийг хайрлаж, хянамгай байна (Сургаалт үгс 8:12).
26. Би согтууруулах ундаанаас зайлсхийх ёстой, учир нь тэдгээр нь муу зан байдалд хүргэдэг (Сургаалт үгс 20:1).
27. Би бусдаас өшөө авахыг оролдох ёсгүй, харин Бурхан шударга ёсыг авчирна гэдэгт итгэж найдах ёстой (Сургаалт үгс 20:22).

28. Би бусадтай тулалдахын оронд энх тайвныг тогтоохыг хичээх ёстой (Сургаалт үгс 3:30, Сургаалт үгс 20:3, Сургаалт үгс 10:12).
29. Би хэзээ ч бусдыг асуудалд оруулахаар худал хэлж болохгүй (Сургаалт үгс 30:10).
30. Хэрэв би итгэл хүлээсэн бол асуудал үүсгэхгүйн тулд нууцыг задруулахгүй (Сургаалт үгс 11:13, Сургаалт үгс 20:19).
31. Хэрэв би сайн зан чанартай бол үнэнийг хэлэх болно (Сургаалт үгс 13:5, Сургаалт үгс 14:5).
32. Би ярихаасаа өмнө сайтар бодох ёстой (Сургаалт үгс 15:28).
33. Би бусдыг хурдан шүүмжилж, зөрчилдөх ёсгүй (Сургаалт үгс 11:12, Сургаалт үгс 17:27).
34. Хэрэв би хурдан уурлаж байвал мунхаг байна (Сургаалт үгс 12:16, Сургаалт үгс 14:29).
35. Хэлж байгаа үгс маань хүмүүсийг өвтгөх биш, харин ерөөдөг байхад би хянамгай байх ёстой (Сургаалт үгс 12:18, Сургаалт үгс 12:25, Сургаалт үгс 16:24, Сургаалт үгс 18:21).
36. Би үргэлж үнэнийг хэлэх ёстой (Сургаалт үгс 4:24, Сургаалт үгс 12:17).
37. Би санаа бодлоо хэлэхээсээ өмнө баримтуудыг сонсох ёстой (Сургаалт үгс 18:13).

38. Хэрэв би хэт их яривал, нүгэлтэй зүйлсийг хэлнэ (Сургаалт үгс 10:19).
39. Би ахмад хүмүүст онцгой хүндэтгэл үзүүлэх ёстой (Сургаалт үгс 16:31, Сургаалт үгс 20:29).
40. Эелдэг байдал, үнэн нь надад Бурханаас ерөөлийг, хүмүүсээс хүндлэл авчирна (Сургаалт үгс 3:3-4).
41. Бурхан намайг хайрладаг учраас буруу зүйл хийхэд минь намайг сахилгажуулах болно (Сургаалт үгс 3:12).
42. Шийдвэр гаргахаасаа өмнө би үр дагаврыг нь бодох ёстой (Сургаалт үгс 22:3).
43. Хэрэв би нүгэл үйлдвэл, би зовлонтой үр дагаврыг амсана (Сургаалт үгс 6:27).
44. Хэрэв би залхуу байвал, дээрэмдүүлсэн мэт гачигдлыг амсана (Сургаалт үгс 6:10-11, Сургаалт үгс 19:15).
45. Би залхуу байж болохгүй, учир нь залхуурал нь эвдрэл сүйрэлтэй адил юм. (Сургаалт үгс 18:9).
46. Би хөдөлмөрлөж, ирээдүйгээ сайжруулах боломжуудыг ашиглах ёстой (Сургаалт үгс 6:6-8, Сургаалт үгс 20:13).
47. Би амьтдад хэрцгий хандаж болохгүй (Сургаалт үгс 12:10).

48. Миний үйлдлүүд надад нэр хүнд авчирдаг (Сургаалт үгс 20:11).
49. Би хүнд хэцүү үед тэсвэрлэж, тууштай байхаар төлөвлөх ёстой (Сургаалт үгс 24:10).
50. Би хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд зөв цагт ажиллахад бэлэн байх ёстой (Сургаалт үгс 10:5, Сургаалт үгс 20:4).
51. Залхуу байдал амьдралд олон асуудал авчирдаг бол харин миний ажил хөдөлмөр боломжуудыг авчирдаг (Сургаалт үгс 15:19, Сургаалт үгс 14:23).
52. Би шударга бус зүйл хийж ашиг олохыг оролдох ёсгүй (Сургаалт үгс 10:2, Сургаалт үгс 11:18, Сургаалт үгс 15:27).
53. Би ажиллаж, хадгалснаар мөнгө олох боломжтой (Сургаалт үгс 10:4, Сургаалт үгс 12:11, Сургаалт үгс 13:11, Сургаалт үгс 21:20, Сургаалт үгс 28:19).
54. Хэрэв би зөв шударга байвал Бурхан намайг хангана (Сургаалт үгс 10:3).
55. Хэрэв би Бурханд өгвөл Тэр миний мөнгө, эд хөрөнгийг ерөөнө (Сургаалт үгс 3:9-10).
56. Би бусдад амласан зүйлээ аль болох хурдан төлөх ёстой (Сургаалт үгс 3:27).

57. Би тусламж хэрэгцээтэй хүмүүст өгөөмөр хандах ёстой (Сургаалт үгс 11:24-25, Сургаалт үгс 14:21, Сургаалт үгс 19:17, Сургаалт үгс 21:13).
58. Миний мөнгө намайг аюулгүй байлгадаггүй, харин миний зөв шударга байдал аюулгүй байлгадаг (Сургаалт үгс 2:7-8, Сургаалт үгс 10:9, Сургаалт үгс 10:25, Сургаалт үгс 11:28).
59. Би өөр хэн нэгний өмнөөс өр төлбөрийг хариуцах ёсгүй (Сургаалт үгс 6:1-3, Сургаалт үгс 17:18).